

## УВС АЙМГИЙН 05-РСАРЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

Увс аймагт анх удаа “Гэрэгэ киоск” төрийн цахим үйлчилгээ үзүүлдэг автомат машиныг оруулж ирлээ. Одоогийн байдлаар улсын бүртгэлийн үйлчилгээ авах боломжтой бөгөөд цаашид үйлчилгээг илүү нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төлбөрийн машиныг үйлчилгээний нэгдсэн төвд байрлуулсан бөгөөд өмнө нь энэхүү үйлчилгээг авахын тулд банк орж цаг хугацаа алддаг байсан бол хэдхэн секундын дотор үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ. Иргэд тус машинаас дараах төрлийн үйлчилгээг авч, төлбөр тооцоо төлөх боломжтой бөгөөд НӨАТ-ын баримт олгодгоороо онцлогтой юм. Улсын бүртгэлийн үйлчилгээ, жолоочийн хариуцлагын даатгал, автотээврийн тэмдэгтийн хураамж, авто машины татвар, торгууль, 1072 хувьцааны данс нээх, орон нутгийн автобусны билет, жимобайл нэгж, мобиком нэгж авах.

Увс аймагт 2016-2019 оны байдлаар сургуулийн хүчин чадал 1400 суудлаар, цэцэрлэгийн хүчин чадал 800 ороор нэмэгдсэн ба 2020 онд сургуулийн хүчин чадал 960, цэцэрлэгийн хүчин чадал 490 ороор нэмэгдэх юм байна.

Монгол улсын Засгийн газар, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар хамтран Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-MONGOLIA төслийг 21 аймагт хэрэгжүүлж эхэллээ. 5 сарын 18-нд Увс аймагт нэвтрүүлж, 19 сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангалаа. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр 21 төрийн байгууллагын 185 үйлчилгээг зөвхөн хурууны хээгээ уншуулан сумаасаа авах бүрэн боломжтой болж, цаг хугацаа хөрөнгө мөнгө хэмнэхээс гадна төрийн үйлчилгээ хүнээс хамааралгүй болж байгаа юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 8 агентлагийн үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, ил тод байдал, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллага, нэгжийн дарга болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, тайлагналтыг хянаж, алдаа дутагдлыг засч залруулах, цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж, мэдээлэл өгч ажиллалаа.

Дэлхий даяар шинэ коронавирусын халдвар тархаж байгаа энэ цаг үед бидний хөрш ОХУ-ын Тува улсад уг өвчний халдвар эрчимтэй тархаж 2020 оны 05 сарын 21-ний өдрийн байдлаар 530 тохиолдол бүртгэгдэж 63 хүн эдгэрсэн байна. Үүний дотор 49 хүүхэд, 6 жирэмсэн эмэгтэй халдвар авчээ. ОХУ-ын Тува улсын ард иргэдэд энэхүү халдварт өвчинтэй тэмцэхэд туслах зорилгоор Увс аймгийн эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөлөөс санаачлан “Мөнхийн хөршдөө тусалъя” аяныг өрнүүллээ. Нийт 280 гаруй хувь хүмүүс, иргэд, гадаад худалдаа эрхлэгчид, 60 гаруй төрийн байгууллага болон ААН хандивын аянд оролцож, 05 сарын 22-29-ний хооронд буюу 7 хоногийн хугацаанд 35,8 сая төгрөг цугларсныг аймгийн Засаг даргад

танилцуулан ОХУ-ын Тува улсын Засгийн газарт хүлээлгэн өгөхөөр бэлтгэл хийж байна

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу төрийн захиргааны зарим албан хаагчдад зэрэг дэв олгож, үнэмлэхийг гардуулан өглөө. Төрийн албаны салбар зөвлөлд төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв оруулахаар 136 албан хаагчийг өргөн мэдүүлснээс хууль журмын шаардлага хангаж буй 115 албан хаагчдад аймгийн Засаг даргын захирамжаар зэрэг дэвийг шинээр болон ахиулан олголоо.

Увс аймгийн Өмнөговь сум “БАНУУН БҮСИЙН ШИЛДЭГ СУМ”-аар шалгарлаа. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийнхээ ашиг орлогыг нэмэгдүүлэх, улсын болон орон нутгийн төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг үр дүнтэй, чанартай хийж, үйлдвэр үйлчилгээг өргөжүүлсэн зэрэг ажлын амжилтаараа 80 гаруй сумаас шалгарсан байна.

2020.05.30-ны 21 цагийн үед аймгийн онцгой комиссын шуурхай штабт Давст сумын хилээр ОХУ-ын Тува улсын талаас 2 монгол иргэн морьтой хил нэвтэрснийг ХЦ 0145-р ангийн заставын 5 ажилтан баривчлан саатуулсан мэдээлэл ирсэн. Шуурхай штабын бие бүрэлдэхүүн Давст суманд ажиллаж, хил зөрчсөн 2 иргэнийг Тува улсын иргэдтэй уулзсан байх магадлалтай гэж үзэж, хилийн цэргийн 5 ажилтан нийт 7 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт 9:00 цагт тусгаарлаж, ажиглалтанд авлаа. Цаашид халдвар хяналтын тандалтыг үргэлжлүүлэн хийж байна.

Гадаад харилцааны чиглэлээр: Агуу их Эх орны дайны Ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан Увс аймгийн ЗДТГ ба ОХУ-ын Тува улсын Засгийн газраас хамтран зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гаргасны дагуу 05 сарын 09-ны Ялалтын баярын өдрийг угтан дунд сургуулийн 9-11-р ангийн сурагчдын дунд “Маршал Жуков-Ялалтын маршал” сэдэвт цахим зохион бичлэгийн уралдааныг аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, БСУГ хамтран зохион байгуулж аймгийн төвийн 6 сургуулиас гадна хөдөө сумдын сургуулиас нийт 30 гаруй сурагчид оролцож дүнгээ гаргасан. Уралдааны шагналыг Тува улсын Боловсрол, шинжлэх ухааны яам ба аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб ивээн тэтгэж сурагчдад гардууллаа.

Хөдөө аж ахуй: Түргэн, Давст суманд байгаа Цөм сүргийн үржлийн төвийн Баяд үүлдрийн хээлтүүлэгч 170, хээлтэгч 1830 нийт 2000 толгой мал, Өлгий сумын Өлгийн улаан үүлдрийн 450 хээлтүүлэгч, 1550 хээлтэгч нийт 2000 толгой ямаа, Наранбулаг сумын Өлгийн улаан үүлдрийн 1500 ямааг үзлэг ангилалтад хамруулж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болон Малын удам зүйн үнэлгээний программд бүрэн орууллаа.

“Мон тува” ХХК-тай 16 тн нөөцийн мах бэлтгэж, өөрийн нэрийн дэлгүүрээр дамжуулан борлуулж эхлээд байна. Хонины махыг 6300, үхрийн махыг 7300 төгрөгөөр тус тус худалдаалж байна.

2020 оны тариалалтын явц одоогийн байдлаар үр тариа 13925 га-д / Үүнээс улаанбуудай 13515 га-д, арвай 55 га-д , тэжээлийн ургамал 890 га-д, тосны ургамал 100 га/, төмс 142,9 га-д, хүнсний ногоо 163,2 га-д тус тус тариалалт хийгдсэн байна. Тариалалт 80 гаруй хувьтай явагдаж байна.

Хүнсний ногоо үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-аас аймгийн 19 сумын тариалагчдад ногооны үр /төл сонгино- 100 кг, луувангийн үр - 160 кг, шар манжингийн үр - 60 кг, хүрэн манжингийн үр - 20 кг, сармис - 3 кг, урт сонгино - 15 кг, байцаа, өргөст хэмх, улаан лооль, чинжүүний үрийг тус тус/ хуваарилан олголоо.

Байгаль орчин: Аймгийн БОАЖГ, ШУА-ийн Биологийн хүрээлэн, тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаатай хамтран 6 сумын монгол тарваганы нөөцийн үнэлгээ, экологийн хээрийн судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгааг хийснээр нийгэм эдийн засгийн хөгжил, байгаль цаг уурын өөрчлөлт хурдацтай явагдаж буй өнөө үед тарваганы идэш тэжээлийн гинжин хэлхээнд гүйцэтгэх үүрэг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг зөв үнэлэх, бодит нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв тогтоох, тоон мэдээлэлд үндэслэн хамгааллын менежментийг боловсруулах ач холбогдолтой юм.

Уул уурхай: Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авах явцдаа зарим баримт бичгээ хуурамчаар бүрдүүлсэн, тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийг буруугаар ашигласан, байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсан зэрэг зөрчил гаргасан Жамц давс /Давстын Шүдэн уулын давс/, Говь эрээн /Түргэний Бургастайн алт/, Их буянт овоо /Өмнөговийн Орлогын голын алт/, Хелиосгоулд /Зүүнхангайн Баянголын алт/ компаниудын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг боловсруулж, албан тоотоор БОАЖЯ-д хүргүүлээд байна.

.....oOo.....